

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Батмөнх	Дугаар	L367
Оршин суугаа аймаг	Булган	Оршин суугаа сум	Гурванбулаг
Төрсөн газар		Төрсөн он	Луу жилтэй
Ажил мэргэжил	Тэтгэвэр авагч		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	үгүй	Сүм хийдийн дугаар	БУДЧ 001 БУГБ 001 БУГБ 003 БУГБ 004 БУГБ 005 БУГБ 006 БУГБ 009БУХӨ 056
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2016.08.25	Ярилцлага авсан хүн	Дэмбэрэл



Батмөнх

1992 онд хүний эрх, эрх чөлөө гарснаар хэлмэгдлийн тухай цагаатгалын хууль батлагдсан. Би тэгэхэд сумын иргэдийн төлөөлөгчдийн хурдын нарийн бичгийн даргаар сонгогдсон. Сумын хэмжээнд 2 хийд байгаа 73 ламын судалгаа гаргаж байсан. МУ-ын цагаатгалын комиссоос цагаан ном гаргасан. Булган аймаг дотор Гурванбулаг сумын сүм хийд, ард түмэн лам нарын үр хүүхэд хань ижил нь цагаатгагдаж 51 хүн нөхөн олговор авч байсан.

**Түдэв гүний хүрээ** - Дашинчилэн сумын лах багийн нутагт байна. Хуучны засаг захиргаагаар Гурванбулаг сумынх. Том хүрээ байсан гэнэ лээ.

**Хөгнө тарны өвгөн хийд** - Сансар сумын нутагт бий. Явган очиж үзнэ. 2 хийд 2 байсан өвгөн хийд, залуу хийд. Даваа гэдэг хандмаа байдаг. Сүүлд нь нэг хурал хурж байхад дуган барьсан.

**Шивэртийн сүм** сүүлд 95-96 оны үеэс 10 хэдэн лам нийлээд хурал хурдаг байсан. Тэгээд сүүлдээ нас өндөр гараад хурлаа хурахаа байсан. Шивэртийн сүмийн хамгийн сүүлийн сахиул лам Доид гэж

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

хүн байсан. Гэр хурал хурж байсан би өөрөө гэрийг нь барьж байсан. Гэрийнх нь унь л байгаа гэж ярьж байсан. Д.Дамдиндорж

**Долоон худгийн хурал** - төв замын хойно 2 цагаан суварга бий. Нэг нь малчны хүүхдүүд аав ээжийнхээ дурсгалд босгосон. Суурь нь байна. Тэр 2 цагаан суварганы яг дэргэд. 2-р багийн нутаг. Хараат уулын зүүнтээ.

**Толийн хурал.** Хөдөөн толь гэж газар ардаа нэг устай, Авзага хайрханы энгэр дээр. Энэбиш гэдэг малчин бий. Энн хүн хурлын талаар мэднэ.

**Батсуурийн хурал** - сумын төв байсан 1955 онд нэгдэл бариад Батсуурийн хурлын дуганы суурийн чулууг ховхлоод чулуун завод бариад, соёлын төвийн клуб барьсан. 4-р багийн нутаг гэдэг. Лувсанцэрэн гэдэг лам хамгийн сүүлд байж байгаад саяхан нас барсан. Яг тэр хурал байсан газар хашаа байоинтай байсан, хүүхдүүд нь сүүлд нь ирээд юмыг нь ачаад явсан.

**Үйзэнгийн хурал** бэрхийн ар одоо нэг цагаан суварга бий. Их цагаан суварга бий, үр хүүхдүүд нь ирээд хурал хураад тахилга хийсэн.

**Зараагын хурал** - сүүл үед байгуулагдаад (1800-1900-аадконы үед) удаагүй алга болсон хурал байх сайн мэдэхгүй. Зараагын голтой.

**Баргын хурал** 1-р багийн нутагт бий. Баргын хурлын лам нарын худаг бий, тэмдэгтэй тод зүйлгүй байх. Түлээт уулын энгэр дээр. Баргууд байхгүй, зүүн талаас нүүж ирсэн нүүдэлчин улсууд байгуулсан. Хамгийн мундаг лам нь Баргын хурлын Вандан лам гэж байсан. Тэр лам удирдаж байсан хурал. Бүр дээр үеийн монгол худаг. Олон ламтай байсан гэдэг.

**Уртын хурал** - баруун уртын голынхоо баруун эрэг дээр туурь байгаа. Уртын гол Авзага хайрхан уулын баруун талаар урагш урсдаг. Байшин бариад хонины ноосоо хийдэг байшин байсан тэр хавьд байдаг. Башигын (Баясгалангийн) Зориг. Могод болон манай сумаас лам нар суудаг том хурал байсан шиг байгаа юм.

**Бургасын хурал**- шургуулга гэдэг газар бий тарнын гол гараад. Дашдорж, Дагва гэж айлууд мэднэ. Монгол худагтай - цагираг байхгүй чулуун дотортой, модон дотортой худаг

**Авзагын хүрээ** - Хишиг -Өндөр сумын уулынхаа зүүн урд энгэр дээр. Сүүлийн лам нь Ловон ширээт гэж лам байсан. 1000 ламтай 4 аймагтай цам гардаг байсан гэдэг. Маарамба зурхайчтай. Алтангэрэл,

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Очир маарамбатай байсан. Зайсантай. Дуган бий. Д.Дамдиндорж нэгдлийн орлогч дарга санааг нь гаргаж энэ зургийг зуруулсан юм. Арьс ширний үйлдвэрийн зураач хамт зурсан байх.

Авзагын хүрээ толь, хараат, баргын долоон худгийн хурлууд жас нийлүүлээд очиж Авзага дээр хурж барьдаг байсан шиг байгаа юм.

Сэрээтэрийн Цэрэндагва гуай. 11-12 той байхад хурал тарчихаад лам нар нь зугтаж алга болсон. Хаалга үүд нь онгорхой эзэнгүй болчихсон байсан гэж ярьдаг. Маарамба байсан Алтангэрэл гуайг дагаж ном сурсан гэдэг.